

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2018 оны 07 сарын 10-ны  
өдрийн 3960 дугаарт бүртгэв.



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2018 оны 6 сарын 29 өдөр

Дугаар 246

Улаанбаатар хот

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны  
зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийг хавсралтаар баталсугай.
2. Тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 26 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн 1-14 дүгээр хавсралт тайланг 2018 оны 3 дугаар улирлаас эхлэн Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг нийт хадгаламж, зээлийн хоршоодод үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

ХАМГААГАХ

УЛСЫН ЗАСАГ

УХАА410 5043239

С.ДАВААСҮРЭН

## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос хадгаламж, зээлийн хоршоо /цаашид "ХЗХ" гэх/-ны санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт /цаашид “Шалгуур үзүүлэлт” гэх/-ийг тогтоох, түүний хэрэгжилтэд хяналт тавихад оршино.

1.2. ХЗХ нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг дараах үндсэн 4 үзүүлэлтийн дагуу тооцож, мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

- 1.2.1. Хөрөнгийн чанарын болон хамгаалалтын үзүүлэлт;
- 1.2.2. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;
- 1.2.3. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;
- 1.2.4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт;

1.3. ХЗХ нь энэхүү шалгуур үзүүлэлтийн 1.2-т заасан үзүүлэлтүүдийг үнэн зөв тооцож, түүний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгааныг тогтоон үнэлэлт, дүгнэлт өгөх замаар ХЗХ-ны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тооцох, түүнээс сэргийлэх арга хэмжээг авна.

1.4. ХЗХ нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн эрсдэлийг үнэлэх, хяналт тавьж, удирдах зорилгоор нэмэлт журмыг дотооддоо боловсруулан мөрдүүлж болно. Тэдгээр нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай болон холбогдох бусад хууль, журамтай нийцсэн байна.

1.5. Хянан шалгагч нь ХЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг хянаж, холбогдох аргачлалын дагуу үнэлгээ хийн хууль, журамд заасан шаардлагатай арга хэмжээг авна. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 23 -ны өдрийн 1022 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

~~1.6. Энэхүү шалгуур үзүүлэлтийн 2.6, 3.1.2, 3.2.2, 3.2.5, 3.2.6, 3.2.7, 4.1.1-д заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй нь Хорооноос тухайн ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохоос бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэл болно. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 23 -ны өдрийн 1022 дугаар тогтоолоор хүчингүйд тооцсон/~~

### Хоёр. Хөрөнгийн чанар, хамгаалалтын үзүүлэлт

2.1. ХЗХ-ны актив хөрөнгийг Хорооноос баталсан холбогдох журмын дагуу ангилж, эрсдэлийн сан байгуулна.

2.2. Зээл, өмчлөх бусад хөрөнгө болон бусад активтай холбоотой гэрээ, хэлцлийн дагуу үүрэг хүлээсэн этгээд нь үндсэн зээл, түүний хүүгийн төлбөрийг бүхэлд нь болон хэсэгчлэн буцаан төлөх чадваргүй болж болзошгүй нь үндэслэл бүхий баримт (зээлийн гэрээний хугацаа дууссан, барьцаа хөрөнгийн чанар муудсан, зах зээлийн үнэ буурсан, байгалийн болон гэнэтийн эрсдэл учирсан гэх мэт)-аар тогтоогдвол ХЗХ нь эрсдэлийн санг зардлаар байгуулна.

2.3. Хэвийн зээл, авлагыг санхүүгийн тайлан тэнцэлд анх тусгаснаас хойш эрсдэлийн сан байгуулсан тохиолдолд санхүүгийн тайланд холбогдох үндэслэл, шийдвэр, баримт материалыг хавсаргаж Хороонд ирүүлнэ.

2.4. Хугацааны ба чанарын үзүүлэлтийг энэ бүлгийн 2.1-д заасан журмын хавсралтад заасан хүчин зүйлсээр тооцон ангилна.

2.5. Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл нь нийт зээлийн багцын 5 хувиас хэтрэхгүй байвал зохино.

2.6. ХЗХ-ны нэг гишүүн болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон нийт зээлийн дүн нь өөрийн хөрөнгийн 30 хувиас ихгүй байвал зохино.

### **Гурав. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт**

#### **3.1. Хөрөнгө**

3.1.1. Цэвэр зээлийн өрийн үлдэгдэл нь нийт хөрөнгийн 60-85 хувь байвал зохино.

3.1.2. ХЗХ-ны цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө нь нийт хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байвал зохино.

#### **3.2. Эх үүсвэр**

3.2.1. Гишүүдээс хадгалуулсан мөнгөн хадгаламжийн нийт дүн нь нийт хөрөнгийн 20-80 хувь байвал зохино.

3.2.2. ХЗХ-ны банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, төсөл, хөтөлбөрийн зээл нь нийт хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байвал зохино.

3.2.3. Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгө нь нийт хувь хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байвал зохино.

3.2.4. Хоршоологчдын өмч нь хандив тусламж, нөөцийн сан, хадгаламж хамгаалалтын сан, тогтворжилтын сан болон бусад сан, хуримтлагдсан орлого (алдагдал)-ын нийлбэрээс бүрдэх бөгөөд нийт хөрөнгийн 5 хувиас доошгүй байвал зохино.

3.2.5. ХЗХ-ны жилийн тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос байгуулах нөөцийн сан нь нийт хөрөнгийн 3 хувиас доошгүй байвал зохино. */Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 23 -ны өдрийн 1022 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

3.2.6. ХЗХ-ны жилийн тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос байгуулах хадгаламж хамгаалалтын сан нь хоршоологчдын өмчийн 5 хувиас доошгүй байвал зохино.

3.2.7. ХЗХ-ны жилийн тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос байгуулах тогтворжилтын сан нь Хоршоологчдын өмчийн 5 хувиас доошгүй байвал зохино.

### **Дөрөв. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт**

4.1. ХЗХ нь дор дурдсан өгөөж, зардлын харьцаануудыг тооцож, санхүү, төлбөрийн чадвар болон бусад үзүүлэлтэд үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

- 1.1.1. ХЗХ-ны үйл ажиллагааны зардал нь нийт хөрөнгийн 15 хувиас хэтрэхгүй байвал зохино.
- 1.1.2. Хөрөнгийн өгөөж нь нэг төгрөгөөс ямар хэмжээний орлого олж байгааг харуулах бөгөөд татварын дараах цэвэр орлогыг нийт хөрөнгөд харьцуулан тооцно.
- 1.1.3. ХЗХ-ны үйл ажиллагаанаас бий болсон үр дүнг хэрхэн удирдаж, хэмнэлт гаргах, санхүүгийн тогтвортой байдал, бодит өсөлтийг хэрхэн удирдахыг тооцоолно.
- 1.1.4. Хүүгийн орлого, нийт дундаж хөрөнгийн харьцааг зээлийн хүүгийн орлогыг нийт хөрөнгийн дундаж үлдэгдэлд харьцуулан тооцно.
- 1.1.5. Хүүгийн зардал, нийт дундаж хөрөнгийн харьцааг бүх төрлийн хүүгийн зардлыг хөрөнгийн дундаж үлдэгдэлд харьцуулан тооцно.
- 1.1.6. Хүүгийн цэвэр орлого, нийт дундаж хөрөнгийн харьцааг бүх төрлийн хүүгийн орлогоос хүүгийн зардлыг хассан дүнг хөрөнгийн дундаж үлдэгдэлд харьцуулан тооцно.
- 1.1.7. Хүүгийн бус орлого, нийт дундаж хөрөнгийн харьцааг ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, бусад төрлийн орлогуудын нийлбэр дүнг хөрөнгийн дундаж үлдэгдэлд харьцуулан тооцно.
- 1.1.8. Хүүгийн бус зардал, нийт дундаж хөрөнгийн харьцааг ханш болон үнэлгээний тэгшитгэлийн зардал, боловсон хүчний холбогдолтой зардал, болзошгүй эрсдэлийн зардал зэрэг хүүгийн бус зардлуудын нийлбэр дүнг хөрөнгийн дундаж үлдэгдэлд харьцуулан тооцно.
- 1.1.9. Эрсдэлийн сангийн зардал, нийт дундаж хөрөнгийн харьцааг бүх төрлийн болзошгүй эрсдэлийн зардлуудын нийт дүнг хөрөнгийн дундаж үлдэгдэлд харьцуулан тооцно.
- 1.1.10. Хүүгийн орлого, хүүгийн орлого оруулдаг нийт дундаж хөрөнгийн харьцааг бүх төрлийн хүүгийн орлогыг хүүгийн орлого оруулдаг нийт хөрөнгийн дундаж үлдэгдэлд харьцуулан тооцно.
- 1.1.11. Зээлийн эрсдэлийн сан, нийт зээлийн өрийн үлдэгдлийн харьцааг зээлийн эрсдэлийн санг нийт зээлийн өрийн үлдэгдэлд тус тус харьцуулан дүгнэлт хийнэ.

#### **Тав. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт**

5.1. Түргэн борлогдох хөрөнгийг касс дахь бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж, гишүүдээс 30 хоногт төлөгдөх зээлийн нийлбэрээр тооцно.

5.2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн түвшинг тооцохдоо түргэн борлогдох хөрөнгөөс гишүүдийн хугацаагүй хадгаламж, 30 хоногт төлөгдөх зээл, бусад богино хугацаат өр төлбөр, гишүүдэд 30 хоногт буцаан олгох хадгаламжийг тус тус хасч, гишүүдээс татан төвлөрүүлсэн 30-аас дээш хоногт төлөгдөх хугацаатай хадгаламж болон урт хугацаат өр төлбөрийн нийлбэрт харьцуулах замаар тооцно. Энэ харьцаа нь 4 хувиас дээш байвал зохино. */Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 23 -ны өдрийн 1022 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

## Зургаа. Бусад

6.1. Энэхүү шалгуур үзүүлэлтэд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байгаа эсэхэд ХЗХ-ны бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомжоор олгогдсон эрхийнхээ хүрээнд хяналт тавьж, хангуулахтай холбогдуулан зохих арга хэмжээг авч ажиллана.

6.2. ХЗХ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг дараах хавсралтуудын дагуу улирал бүр тооцож, тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ. Үүнд:

- 6.2.1. Хураангуй тайлан, тэнцэл /Хавсралт 1/;
- 6.2.2. Орлогын дэлгэрэнгүй тайлан /Хавсралт 2/;
- 6.2.3. Зээл олголт, эргэн төлөлт, зээлийн зориулалт, хүүгийн судалгааны тайлан /Хавсралт3/;
- 6.2.4. Хадгаламж, хадгаламжийн хүүгийн судалгаа /Хавсралт 4/;
- 6.2.5. 40 том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгийн тайлан /Хавсралт 5/; */Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 23 -ны өдрийн 1022 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 6.2.6. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгийн тайлан /Хавсралт 6/;
- 6.2.7. 40 Том хадгаламж эзэмшигчийн тайлан /Хавсралт 7/; */Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 23 -ны өдрийн 1022 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 6.2.8. Их хэмжээний хувь хөрөнгө нийлүүлсэн гишүүдийн тайлан /Хавсралт 8/;
- 6.2.9. Хөрөнгө, эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацааны тайлан /Хавсралт 9/;
- 6.2.10. Хөрөнгийн чанар, хамгаалалтын үзүүлэлтийн тайлан /Хавсралт 10/;
- 6.2.11. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлтийн тайлан /Хавсралт 11/;
- 6.2.12. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлтийн тайлан /Хавсралт 12/;
- 6.2.13. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийн тайлан /Хавсралт 13/;
- 6.2.14. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт /Хавсралт 14/.

6.3. Зах зээлийг дэмжих болон бусад тодорхой бодлого, зохицуулалтын арга хэмжээний хүрээнд Хорооны шийдвэрээр зарим шалгуур үзүүлэлтийг ялгаатай байдлаар тооцох эсхүл зарим үзүүлэлтийг тооцохгүй байхаар тогтоож болно. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 23 -ны өдрийн 1022 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

6.4. Энэхүү шалгуур үзүүлэлтийг мөрдөгдөж эхэлснээс хойш хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ХЗХ нь Хорооноос тусгай зөвшөөрөл олгосноос хойшхи 4 улиралд багтаан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байх үүргийг хүлээнэ.

6.5. “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-д заасны дагуу зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангагдаагүй үндэслэлээр тухайн ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон бусад арга хэмжээг авч эхлэх тайлант хугацааны эхлэлийг энэ журмын 6.4-д заасан хугацаанаас хойш тооцно.

**ХУРААНГУЙ ТАЙЛАН ТЭНЦЭЛ**  
**/Хадгаламж, зээлийн хоршооны нэр/  
ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

/0000/СС/ӨӨ/

/төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	Үлдэгдэл		Нийт хөрөнгө д эзлэх хувь	ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	Үлдэгдэл		Нийт хөрөнгө д эзлэх хувь
	1-р сарын 0	...-р сарын			1-р сарын 01	... -р сарын	
<b>1.Эргэлтийн хөрөнгө</b>				<b>1.Өр төлбөр</b>			
<b>1.1 МӨНГӨН ХӨРӨНГ</b>				<b>1.1 ХАДГАЛАМЖ</b>			
Бэлэн мөнгө Банкинд байршуулсан харилцах Банкинд байршуулсан хадгаламж				Хугацаагүй Хугацаатай			
<b>1.2 БОГИНО ХУГАЦАА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>							
Арилжааны үнэт цаас							
<b>1.3 ЗЭЭЛ /ЦЭВРЭЭР/</b>				<b>1.2 БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ</b>			
Нийт зээл Хэвийн зээл Хугацаа хэтэрсэн зээл Чанаргүй зээл Хэвийн бус Эргэлзээтэй зээл Муу зээл (Зээлийн эрсдэлийн с				Банкнаас авсан зээл Санхүүгийн байгууллагаас авсан зээл Төсөл хөтөлбөрөөс авсан зээл Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа			
<b>1.4 АВЛАГА</b>				<b>1.3 БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
Байгууллага, хүмүүсээс авах авлага Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага				Цалингийн өглөг Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг Ногдол ашгийн өглөг Санхүүгийн түрээсийн өглөг Санхүүгийн			

						түрээсийн хэрэгжээгүй орлого Урьдчилж орсон орлого Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг Салбар хоорондын тооцоогоорх өглөг Бусад богино хугацаат өглөг			
<b>1.5</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙ ХӨРӨНГӨ</b>				<b>1.4</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
	Татварын авлага Урьдчилж төлсөн зардал, тооцоо Дараа тайлангийн тооцоо Дугагдал, шамшигдал Хангамжийн зүйлс Салбар хоорондын авлага					Банкнаас авсан зээл Санхүүгийн байгууллагаас авсан зээл Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа Хойшлогдсон татварын өр төлбөр			
<b>1.6</b>	<b>ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/</b>				<b>2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>				
	Өмчлөх бусад хөрөнгө (Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга)				<b>2.1</b>	<b>ГИШҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ ХӨРӨНГӨ</b>			
<b>2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>						Гишүүний оруулсан хувь хөрөнгө Идэвхигүй гишүүний оруулсан хувь хөрөнгө			
<b>2.1</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/</b>				<b>VI</b>	<b>ХОРШООЛОГЧД ЫН ӨМЧ</b>			
	Үндсэн хөрөнгө (Хуримтлагдсан элэгдэл)					Нөөцийн сан Хандив, тусламж Хадгаламж, хамгаалалтын сан Нийгмийн хөгжлийн сан Тогтворжилтын сан Бусад сангууд Хуримтлагдсан орлого /алдагдал/ Тайлангийн үеийн цэвэр орлого Өмнөх үеийн цэвэр орлого			
<b>2.2</b>	<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>								
	Биет бус хөрөнгө (Биет бус хөрөнгийн элэгдэл)								
<b>2.3</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>								
	Хөрөнгө оруулалт ба эргэлтийн бус								

	хөрөнгө								
	ХӨРӨНГИЙН ДҮН			100%		НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН			100%

ТАМГА

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал

/Нэр/

Ерөнхий ня-бо

/Нэр/

**СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ НЭР**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

д/д	СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ДУН/ТОО
<b>I</b>	<b>ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ</b>	
	<b>Нийт гишүүдийн тоо</b>	-
1	Эрэгтэй	-
	Эмэгтэй	-
	Гишүүн хуулийн этгээд	-
	<b>Гишүүдийн насжилт</b>	-
2	18-35 насны	-
	36-45 насны	-
	46-55 насны	-
	55-аас дээш	-
	<b>Гишүүдийн боловсрол</b>	-
3	Дээд	-
	Тусгай дунд	-
	Бүрэн дунд	-
	Дунд	-
	Бага	-
<b>II</b>	<b>ЗЭЭЛДЭГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ</b>	
	<b>Нийт зээлдэгчдийн тоо</b>	-
4	Иргэн	-
	Үүнээс: Эмэгтэй	-
	Хуулийн этгээд	-
	<b>Зээлдэгчдийн тоо зээлийн ангиллаар</b>	-
5	Хэвийн	-
	Хугацаа хэтэрсэн	-
	<b>Чанаргүй:</b>	-
	Хэвийн бус	-
	Эргэлзээтэй	-
	Муу	-
	<b>Зээлдэгчдийн насжилт</b>	-
6	18-35 насны	-
	36-45 насны	-
	46-55 насны	-
	55-аас дээш	-
	<b>Зээлдэгчдийн боловсрол</b>	-
7	Дээд	-
	Тусгай дунд	-
	Бүрэн дунд	-
	Дунд	-
	Бага	-
8	<b>Зээлийн ЖДХ</b>	-
<b>III</b>	<b>ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ</b>	
	<b>Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо</b>	-
9	Хугацаатай хадгаламж эзэмшигчдийн тоо	-
	-Иргэн	-
	Үүнээс: Эмэгтэй	-
	-Хуулийн этгээд	-
	Хугацаагүй хадгаламж эзэмшигчдийн тоо	-

	-Иргэн	-
	Үүнээс: Эмэгтэй	-
	-Хуулийн этгээд	-
10	<b>Хадгаламж эзэмшигчдийн насжилт</b>	-
	18-35 насны	-
	36-45 насны	-
	46-55 насны	-
	55-аас дээш	-
11	<b>Хадгаламж эзэмшигчдийн боловсрол</b>	-
	Дээд	-
	Тусгай дунд	-
	Бүрэн дунд	-
	Дунд Бага	-
12	<b>Хадгаламжийн ЖДХ</b>	-
<b>IV</b>	<b>ХЗХ-НЫ МЭДЭЭЛЭЛ</b>	
13	<b>Нийт ажиллагчийн тоо</b>	-
	Үүнээс: эмэгтэй	-
	<b>Салбарын ажиллагчийн тоо /салбартай бол/</b>	
14	<b>Компьютерын тоо</b>	-
15	Санхүүгийн программтай эсэх /Тийм, Үгүй сонгох/	
	Санхүүгийн программын нэр	
16	<b>Холбоо барих</b>	
	ХЗХ-ны утас	
	ХЗХ-ны цахим шуудан	
<b>V</b>	<b>СМА-НД МЭДЭЭЛСЭН БАЙДАЛ</b>	
17	<b>Монголбанкны СМА-нд мэдээлсэн 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээ /оны эхнээс өссөн дүнгээр/</b>	
	20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээний тоо	
	20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээний дүн /төгрөгөөр/	
	<b>Монголбанкны СМА-нд мэдээлсэн сэжигтэй гүйлгээний дүн /оны эхнээс өссөн дүнгээр/</b>	
	Сэжигтэй гүйлгээний тоо	
	Сэжигтэй гүйлгээний дүн /төгрөгөөр/	

### ТАМГА

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал

Ерөнхий ня-бо

/Нэр/

/Нэр/

**ГҮЙЛГЭЭ ҮЛДЭГДЛИЙН ТАЙЛАН ТЭНЦЭЛ**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ НЭР**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

/төгрөгөөр/

АКТИВ		Дансны дугаар	.... р сарын ...	ПАССИВ		Дансны дугаар	.... р сарын ...
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>			-	<b>ӨР ТӨЛБӨР</b>			-
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>			-	<b>ХАДГАЛАМЖ</b>			-
	Бэлэн мөнгө		-		Хугацаагүй хадгаламж		-
	Бэлэн мөнгө	1001	-		Хугацаагүй хадгаламж	3101	-
	Жижиг мөнгөн сан	1002	-		Идэвхгүй гишүүний хугацаагүй хадгаламж	3105	-
	Банкинд байршуулсан харилцах		-		Хугацаатай хадгаламж		-
	Банкин дахь харилцах данс	1110	-		Хугацаатай хадгаламж	3110	-
	Бусад санхүүгийн байгууллага дахь харилцах данс	1112	-	<b>БАНК БУС НЭГЖИД ТӨЛӨХ ӨГЛӨГ</b>			-
	Банкинд байршуулсан хадгаламж		-		Төсөл, хөтөлбөрийн зээл	3120	-
	Банкин дахь хугацаагүй хадгаламж	1120	-		Богино хугацаат төсөл, хөтөлбөрийн зээл		-
	Банкин дахь хугацаатай хадгаламж	1122	-		Урт хугацаат төсөл, хөтөлбөрийн зээл		-
<b>ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)</b>			-		Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа	3121	-
	Хэвийн зээл		-		Богино хугацаат тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа		-
	Хэвийн зээл	1210	-		Урт хугацаат тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа		-
	Хугацаа хэтэрсэн зээл		-	<b>БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ</b>			-
	Хугацаа хэтэрсэн зээл	1220	-		Банкнаас авсан зээл		-
	Хэвийн бус зээл		-		Банкнаас авсан богино хугацаат зээл	3130	-
	Хэвийн бус зээл	1230	-		Банкнаас авсан урт хугацаат зээл	3131	-
	Эргэлзээтэй зээл		-		Санхүүгийн байгууллагаас авсан зээл		-
	Эргэлзээтэй зээл	1240	-		Санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл	3140	-
	Муу зээл		-		Санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл	3141	-
	Муу зээл	1250	-	<b>БУСАД ӨР ТӨЛБӨР</b>			-
	<b>Зээлийн эрсдэлийн сан</b>		-		Бусад өглөг		-
	<i>Зээлийн эрсдэлийн сан</i>	<i>1260</i>	-		Цалингийн өглөг	3150	-
<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>			-		Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн өглөг	3151	-
	Арилжааны үнэт цаас		-		Хувь хүний орлогын албан татварын өглөг	3152	-
	Арилжааны үнэт цаас	1301	-		Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	3153	-

<b>ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)</b>			-				
	Өмчлөх бусад хөрөнгө		-				
	Өмчлөх бусад хөдлөх хөрөнгө	1401	-				
	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	1402	-				
	<b>Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга</b>		-				
	<i>Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга</i>	<i>1403</i>	-				
<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>			-				
	Бусад эргэлтийн хөрөнгө		-				
	Байгууллага, хувь хүмүүсээс авах авлага	1501	-				
	Татварын авлага	1502	-				
	Урьдчилж төлсөн тооцоо	1503	-				
	Дараа тайлангийн тооцоо	1504	-				
	Дутагдал, шамшигдал	1505	-				
	Хангамжийн зүйлс	1506	-				
	Урьдчилж төлсөн түрээсийн зардал	1507	-				
	Урьдчилж төлсөн даатгалын зардал	1508	-				
	Урьдчилж төлсөн орлогын албан татвар	1509	-				
	Салбар хоорондын тооцоо		-				
	Салбар хоорондын авлага	1510	-				
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага		-				
	Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	1520	-				
	Хуримтлуулж тооцсон хадгаламжийн хүүгийн авлага	1530	-				
	Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн авлага	1540	-				
	Санхүүгийн түрээсийн хүүгийн авлага	1550	-				
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>			-				
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/</b>			-				
	Үндсэн хөрөнгө		-				
	Газар	2001	-				
	Барилга	2002	-				
	Тавилга, эд хогшил	2003	-				
	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	2004	-				
	Компьютер, дагалдах хэрэгсэл	2005	-				
	Үндсэн хөрөнгийн санхүүжилт	2006	-				
	Бусад үндсэн хөрөнгө	2007	-				
	<b>Хуримтлагдсан элэгдэл</b>		-				
	Барилга	2010	-				
	Тавилга, эд хогшил	2011	-				
	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	2012	-				
	Орлогын албан татварын өглөг	3154	-				
	Ногдол ашгийн өглөг	3155	-				
	Идэвхгүй гишүүний ногдол ашгийн өглөг	3156	-				
	Санхүүгийн түрээсийн өглөг	3157	-				
	Бусад өр төлбөр	3158	-				
	Хойшлогдсон татварын өр төлбөр	3159	-				
	Салбар хоорондын тооцоо		-				
	Салбар хоорондын тооцоогоорх өглөг	3160	-				
	<b>Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг</b>		-				
	Хуримтлуулж тооцсон хадгаламжийн хүүгийн өглөг	3170	-				
	Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг	3171	-				
	Санхүүгийн түрээсийн хүүгийн өглөг	3172	-				
<b>УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО</b>			-				
	Урьдчилж орсон зээлийн хүүгийн орлого	3201	-				
	Урьдчилж орсон санхүүгийн түрээсийн орлого	3202	-				
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>			-				
<b>ГИШҮҮНИЙ ОРУУЛСАН ХУВЬ ХӨРӨНГӨ</b>			-				
	Гишүүний оруулсан хувь хөрөнгө	4101	-				
	Идэвхгүй гишүүний оруулсан хувь хөрөнгө	4110	-				
<b>ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ</b>			-				
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4120	-				
<b>ХАНДИВ, ТУСЛАМЖ</b>			-				
	Хандив	4130	-				
	Тусламж	4131	-				
<b>САНГУУД</b>			-				
	Нөөцийн сан	4140	-				
	Хадгаламж хамгаалалтын сан	4141	-				
	Нийгмийн хөгжлийн сан	4142	-				
	Бусад сан	4143	-				
	Тогтворжилтын сан	414310	-				
	Бусад сан	414320	-				
<b>ХУРИМТЛАГДСАН ОРЛОГО /АЛДАГДАЛ/</b>			-				
	Цэвэр орлого (алдагдал)	4150	-				
	Хуримтлагдсан орлого (алдагдал)	4160	-				
<b>ОРЛОГО</b>			-				
	Хүүгийн орлого		-				
	Зээлийн хүүгийн орлого	5101	-				
	Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	5102	-				

	Компьютер, дагалдах хэрэгсэл	2013	-
	Бусад үндсэн хөрөнгө	2014	-
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>			-
	Биет бус хөрөнгө		-
	Патент	2101	-
	Зохиогчийн эрх	2102	-
	Программ хангамж	2103	-
	Франчайз	2104	-
	Бусад биет бус хөрөнгө	2105	-
	<i>Хуримтлагдсан элэгдэл</i>		-
	Биет бус хөрөнгийн элэгдэл	2015	-
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>			-
	Урт хугацаат өрийн бичиг	2201	-
	Бусад урт хугацаат хөрөнгө оруулалт	2202	-
	Хойшлогдсон татварын хөрөнгө	2210	-
<b>ЗАРДАЛ</b>			-
	Хүүгийн зардал		-
	Хадгаламжийн хүүгийн зардал	7001	-
	Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	7002	-
	Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	7003	-
	Бусад хүүгийн зардал	7004	-
	Хүүгийн зардлын буцаалт	7010	-
	Болзошгүй эрсдэлийн зардал		-
	Зээлийн эрсдэлийн зардал	7021	-
	Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын гарз	7022	-
	Болзошгүй эрсдэлийн зардлын нөхөлт	7030	-
	Боловсон хүчний холбогдолтой зардал		-
	Ажилтнуудын цалингийн зардал	7041	-
	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	7042	-
	Ажиллагсдын сургалтын зардал	7043	-
	Гэрээт ажиллагсдын цалингийн зардал	7044	-
	Ажилтнуудад олгосон нөхөн олговрын зардал	7045	-
	Ажилтнуудад олгосон нэмэгдэл, хөнгөлөлтийн зардал	7046	-
	Боловсон хүчний бусад зардал	7047	-
	Бусад үйл ажиллагааны зардал		-
	Зээл болон бусад авлагыг барагдуулахтай холбогдолтой зардал	7050	-
	ХЗХ-дын Үндэсний Холбооны гишүүний татвар	7051	-

Үнэт цаасны хүүгийн орлого	5110	-
Банкнаас авсан хүүгийн орлого	5120	-
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого	5130	-
Зээлийн хүүгийн орлогын буцаалт	5140	-
<b>Хүүгийн бус орлого</b>		-
Элсэлтийн хураамж	5141	-
Гишүүний татвар	5142	-
Үйлчилгээний шимтгэл, хураамж	5143	-
Түрээсийн орлого	5144	-
Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого	5150	-
<b>Үйл ажиллагааны бусад орлого, олз</b>		-
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	5181	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	5182	-
Үнэт цаасны арилжааны орлого	5183	-
Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	5184	-
Торгуулийн орлого	5185	-
Бусад орлого	5190	-

Тогтворжилтын үйлчилгээний шимтгэл	7052	-
Аудит, мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардал	7053	-
Франчайзын хураамж	7054	-
Даатгалын зардал	7055	-
Улсын тэмдэгтийн хураамж	7056	-
Хадгаламжийн даатгалын хураамж	7057	-
Зохицуулалтын үйлчилгээний хөлс	7058	-
Элэгдэл, хорогдлын зардал	7059	-
Түрээсийн зардал	7060	-
Ашиглалтын зардал	7061	-
Үндсэн хөрөнгийн засварын зардал	7062	-
Бичиг хэргийн зардал	7063	-
Харуул, аюулгүй байдлын зардал	7064	-
Шуудан, холбооны зардал	7065	-
Зочин төлөөлөгчийн зардал	7066	-
Шатахуун, тээврийн зардал	7067	-
Захиалгат хэвлэлийн зардал	7068	-
Ариун цэврийн зардал	7069	-
Газрын төлбөр	7070	-
Гишүүдийн сургалт, судалгааны зардал	7071	-
Албан томилолтын зардал	7072	-
Хурал зохион байгуулах зардал	7073	-
Өмчлөх бусад хөрөнгийн урсгал зардал	7074	-
Үйл ажиллагааны бусад зардал	7075	-
<b>Бусад зардал, гарз</b>		-
Торгуулийн зардал	7080	-
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	7081	-
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	7082	-
Үнэт цаасны арилжааны алдагдал	7083	-
Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн зардал	7084	-
Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны гарз	7085	-
Өмчлөх бусад хөрөнгийг данснаас хассаны гарз	7086	-
Хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарз	7087	-
Хөрөнгийн дахин үнэлгээний гарз	7088	-
Бусад зардал	7089	-
<b>Орлогын албан татварын зардал</b>		-
Орлогын албан татварын зардал	9101	-
<b>БАЛАНСЫН ДҮН</b>		-
<b>БАЛАНСЫН ДҮН</b>		-

Тайлант үеийн орлого/ алдагдал

Нийт орлого

Нийт зарлага

БАЛАНСЫН ГАДУУРХ ДАНС	Дансны дугаар	
		... р сарын ...
<b>Хүлээж болзошгүй үүрэг</b>		-
Батлан даалт	9901	-
Зээлийн барьцаа хөрөнгө	9902	-
Зээлийн шугам	9903	-
<b>Үнэ бүхий зүйл</b>		-
Нарийн бүртгэлийн маягтууд	9910	-
Хадгалсан үнэ бүхий зүйлс	9911	-
Хэрэглэж буй тэмдгүүд	9915	-
<b>Зээлтэй холбогдох тооцоо</b>		-
Зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээл	9920	-
Хуримтлуулж тооцохыг зогсоосон хүү	9921	-

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал

/Нэр/

Ерөнхий ня-бо

/Нэр/

**ХУРААНГУЙ ТАЙЛАН ТЭНЦЭЛ**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ НЭР**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

/төгрөгөөр/

ХӨРӨНГӨ		.... р сарын ...	Нийт хөрөнгөд эзлэх хувь	ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		.... р сарын ...	Нийт хөрөнгөд эзлэх хувь
<b>1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>				<b>1. ӨР ТӨЛБӨР</b>			
1.1	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>			1.1	<b>ХАДГАЛАМЖ</b>		
	Бэлэн мөнгө				Хугацаагүй		
	Банкинд байршуулсан харилцах				Хугацаатай		
	Банкинд байршуулсан хадгаламж			1.2	<b>БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ</b>		
1.2	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>				Банкнаас авсан зээл		
	Арилжааны үнэт цаас				Санхүүгийн байгууллагаас авсан зээл		
1.3	<b>ЗЭЭЛ /ЦЭВРЭЭР/</b>				Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл		
	<b>Нийт зээл</b>				Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа		
	Хэвийн зээл			1.3	<b>БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
	Хугацаа хэтэрсэн зээл				Цалингийн өглөг		
	<b>Чанаргүй зээл</b>				Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг		
	Хэвийн бус зээл				Ногдол ашгийн өглөг		
	Эргэлзээтэй зээл				Санхүүгийн түрээсийн өглөг		
	Муу зээл				Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого		
	(Зээлийн эредэлийн сан )				Урьдчилж орсон орлого		
1.4	<b>АВЛАГА</b>				Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг		
	Байгууллага, хүмүүсээс авах авлага				Салбар хоорондын тооцоогоорх өглөг		
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага				Бусад богино хугацаат өглөг		
1.5	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>			1.4	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
	Татварын авлага				Банкнаас авсан зээл		
	Урьдчилж төлсөн зардал, тооцоо				Санхүүгийн байгууллагаас авсан зээл		
	Дараа тайлангийн тооцоо				Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл		
	Дутагдал, шамшигдал				Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа		

	Хангамжийн зүйлс				Хойшлогдсон татварын өр төлбөр		
	Салбар хоорондын авлага				<b>2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		
1.6	<b>ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/</b>			2.1	<b>ГИШҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ ХӨРӨНГӨ</b>		
	Өмчлөх бусад хөрөнгө (Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга)				Гишүүний оруулсан хувь хөрөнгө		
					Идэвхгүй гишүүний оруулсан хувь хөрөнгө		
	<b>2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>			2.2	<b>ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ</b>		
2.1	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/</b>				Дахин үнэлгээний нэмэгдэл		
	Үндсэн хөрөнгө (Хуримтлагдсан элэгдэл)			2.3	<b>ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ</b>		
2.2	<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>				Нөөцийн сан		
	Биет бус хөрөнгө (Биет бус хөрөнгийн элэгдэл)				Хандив, тусламж		
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>				Хадгаламж, хамгаалалтын сан		
2.3	Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө				Нийгмийн хөгжлийн сан		
					Тогтворжилтын сан		
					Бусад сангууд		
					Хуримтлагдсан орлого /алдагдал/		
					Тайлангийн үеийн цэвэр орлого		
					Өмнөх үеийн цэвэр орлого		
<b>ХӨРӨНГИЙН ДҮН</b>				<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>			

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал /Нэр/

Ерөнхий ня-бо /Нэр/

**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ НЭР**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		... р сарын ...	ХУВЬ
<b>I</b>	<b>ХҮҮГИЙН ОРЛОГО</b>		
	Зээлийн хүүгийн орлого		
	Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого		
	Үнэт цаасны хүүгийн орлого		
	Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого		
	Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого		
	(Зээлийн хүүгийн орлогын буцаалт )		
<b>II</b>	<b>ХҮҮГИЙН ЗАРДАЛ</b>		
	Хадгаламжийн хүүгийн зардал		
	Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал		
	Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал		
	Бусад хүүгийн зардал		
	(Хүүгийн зардлын буцаалт)		
<b>Хүүгийн цэвэр орлого</b>			
<b>III</b>	<b>БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ</b>		
	Зээлийн эрсдэлийн зардал		
	Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал (Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)		
<b>Болзошгүй эрсдэлийн сангуудын дараах цэвэр орлого</b>			
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО</b>		
	Элсэлтийн хураамж		
	Гишүүний татвар		
	Үйлчилгээний шимтгэл, хураамж		
	Түрээсийн орлого		
	Санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого		
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		
	<b>Боловсон хүчний зардал</b>		
	Ажилтнуудын цалингийн зардал		
	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал		
	Ажиллагсдын сургалтын зардал		
	Гэрээт ажиллагсдын цалингийн зардал		
	Ажилтнуудад олгосон нөхөн олговрын зардал		
	Ажилтнуудад олгосон нэмэгдэл, хөнгөлөлтийн зардал		
	Боловсон хүчний бусад зардал		
	<b>Бусад төрлийн зардал</b>		
	Зээл болон бусад авлагыг барагдуулахтай холбоотой зардал		
	Үндэсний холбооны гишүүний зардал		
	Тогтворжилтын үйлчилгээний шимтгэл		
	Аудит, мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардал		
	Франчайзийн хураамж		
	Даатгалын зардал		
	Улсын тэмдэгтийн хураамж		
	Хадгаламжийн даатгалын зардал		
	Зохицуулалтын үйлчилгээний хөлс		
	Элэгдэл хорогдлын зардал		

	Түрээсийн зардал		
	Ашиглалтын зардал (цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус)		
	Үндсэн хөрөнгийн засвар, борлуулалтын зардал		
	Бичиг хэргийн зардал		
	Харуул, аюулгүй байдлын зардал		
	Шуудан холбооны зардал		
	Зочин төлөөлөгчийн зардал		
	Шатахуун , тээврийн зардал		
	Захиалгат хэвлэлийн зардал		
	Ариун цэврийн зардал		
	Газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар		
	Гишүүдийн сургалт, судалгааны зардал		
	Албан томилолтын зардал		
	Хурал зохион байгуулах зардал		
	Өмчлөх бусад хөрөнгийн урсгал зардал		
	Үйл ажиллагааны бусад зардал		
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>			
<b>VI ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>			
	Үндсэн хөрөнгө борлуулсны олз Гадаад валютын ханшийн зөрүүний олз Үнэт цаасны арилжааны орлого Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого Торгуулийн орлого Бусад орлого		
<b>VII ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>			
	Торгуулийн зардал Үндсэн хөрөнгө борлуулсны гарз Гадаад валютын ханшийн зөрүүний гарз Үнэт цаасны арилжааны алдагдал Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн зардал Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны гарз Өмчлөх бусад хөрөнгийг данснаас хассаны гарз Хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарз Хөрөнгийн дахин үнэлгээний гарз Үйл ажиллагааны бус бусад зардал		
<b>X ТАТВАРЫН ӨМНӨХ ЦЭВЭР ОРЛОГО</b>			
	Татварын зардал		
<b>XI ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР ОРЛОГО</b>			

**НИЙТ ОРЛОГО:**

--	--

**НИЙТ ЗАРЛАГА:**

--	--

**ЦЭВЭР ОРЛОГО**

--	--

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал

/Нэр/

Ерөнхий ня-бо

/Нэр/





5-аас дээш жилийн хугацаатай олгосон зээл													
<b>4.Зээлийн ангиллаар</b>													
Иргэнд олгосон зээл													
Хэрэглээний зээл													
Бизнесийн зээл													
Автомашинны зээл													
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл													
Бусад зээл													
Хуулийн этгээдэд олгосон зээл													
Бизнесийн зээл													
Автомашинны зээл													
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл													
Бусад зээл													
<b>НИЙТ</b>													
<b>5.Ногоон зээл</b>													
Иргэнд олгосон зээл													
Хуулийн этгээдэд олгосон зээл													
<b>НИЙТ</b>													

**Судалгааны маягтыг бөглөх дарааллын товч заавар:**

- 1/ Зээлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилахад Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ыг баримтална.
- 2/ Бусад үйл ажиллагаанд Урлаг, үзвэр, тоглоом наадам , үйлчилгээний бусад үйл ажиллагаа, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, хэмжээг нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ , Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа зэрэг салбаруудыг оруулна.Түүнчлэн, цалин, хэрэглээ, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан, картын зээлийг мөн бусад үйл ажиллагаанд оруулна.
- 3/ ЗЖДХ гэдэгт тайлант улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг ойлгоно.
- 4/ Ногоон зээлийг холбогдох аргачлалын дагуу тодорхойлно.
- 5/ XXXX нүдийг бөглөхгүй.

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал            /Нэр/  
Ерөнхий ня-бо                 /Нэр/



НИЙТ														
д/д	Хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүн	Хугацаатай хадгаламжийн эхний үлдэгдэл	Тоо	Тайлан хугацаанд татан төвлөрүүлсэн хугацаатай хадгаламжийн дүн	Тоо	Сарын нэрлэсэн хүү /хувиар/	Хуримтлагдсан хүүгийн дүн	Жигнэсэн дундаж хүү	Тайлант хугацаанд буцаан олгосон хадгаламжийн дүн	Тоо	Хугацаатай хадгаламжийн эцсийн үлдэгдэл	Тоо	Дээд хүү /сарын/	Доод хүү /сарын/
<b>3.Иргэн</b>														
1														
2														
3														
4														
5														
6														
7														
8														
9														
10														
Дүн														
<b>4.Хуулийн этгээд</b>														
1														
2														
3														
4														
5														
6														
7														
8														
9														
10														
Дүн														
НИЙТ														
<b>5. Хадгаламж, хугацааны ангиллаар</b>														
30 хоног хүртэл хугацаатай хадгаламж														
1-3 сарын хугацаатай хадгаламж						XXXX					XXXX			
3-6 сарын хугацаатай хадгаламж														
6-12 сарын хугацаатай хадгаламж														

1-2 жилийн хугацаатай хадгаламж					
2-5 жилийн хугацаатай хадгаламж					
5-аас дээш жилийн хугацаатай хадгаламж					
<b>НИЙТ</b>					

**Судалгааны маягтыг бөглөх дарааллын товч заавар:**

- 1/ "Сарын нэрлэсэн хүү" талбарыг бөглөх ба ингэхдээ зөвхөн тухайн тайлант улиралд татан төвлөрүүлсэн хадгаламжийн хүүг үндэслэл болгоно.
- 2/ "Тайлант хугацаанд татан төвлөрүүлсэн хадгаламжийн дүн" талбарыг бөглөх ба ингэхдээ нэрлэсэн хүү тус бүрээр татан төвлөрүүлсэн хадгаламжийн нийлбэр дүнгээр тооцож оруулна.
- 3/ "Хүүгийн хэмжээ" талбарын тооцоолол томьёоны дагуу хийгдэнэ.
- 4/ "Жигнэсэн дундаж хүү" талбарын тооцоолол томьёоны дагуу гүйцэтгэгдэнэ.
- 5/ "Дээд, доод хүү"-г тайлант хугацаанд үлдэгдэлтэй нийт хадгаламжийн хүүгээр тооцно.
- 6/ XXXX нүдийг бөглөхгүй

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх  
захирал /Нэр/  
Ерөнхий ня-бо /Нэр/



25														
26														
27														
28														
29														
30														
31														
32														
33														
34														
35														
36														
37														
38														
39														
40														
НИЙТ				-										

Хамгийн том зээлдэгч:

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал /Нэр/

Ерөнхий ня-бо /Нэр/







24									
25									
26									
27									
28									
29									
30									
31									
32									
33									
34									
35									
36									
37									
38									
39									
40									
БҮГД		-							

Хамгийн өндөр хадгаламж эзэмшигч

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх  
захирал

/Нэр/

Ерөнхий ня-бо

/Нэр/

**ИХ ХЭМЖЭЭНИЙ ХУВЬ ХӨРӨНГӨ НИЙЛҮҮЛСЭН ГИШҮҮДИЙН ТАЙЛАН**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ НЭР**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

/төгрөгөөр/

д/д	Хувь хөрөнгө нийлүүлсэн гишүүний нэр*	Оруулсан хувь хөрөнгийн тайлант үеийн үлдэгдэл	ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			
9			
10			
11			
12			
13			
14			
15			
16			
17			
18			
19			
20			
21			
22			
23			
24			
25			

26		
27		
28		
29		
30		
31		
32		
33		
34		
35		
36		
37		
38		
39		
40		
БҮГД		-
Хамгийн том хувь нийлүүлэгч		-

\* ХЗХ-ны хамгийн том хувь нийлүүлэгчдийн нэрийг бичнэ.

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал

/Нэр/

Ерөнхий ня-бо

/Нэр/

**ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭРИЙН ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ХУГАЦААНЫ ТАЙЛАН**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ НЭР**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

/төгрөгөөр/

Хөрөнгө, эх үүсвэр		Хугацаагүй	30 хоног хүртэл	1-3 сар	3-6 сар	6-12 сар	1-2 жил	2-5 жил	5 жилээс дээш	Нийт
<b>Хөрөнгө</b>										
1	Бэлэн мөнгө									
2	Банкинд байршуулсан харилцах									
3	Банкинд байршуулсан хадгаламж									
4	Зээл	XXXX								
5	Бусад*									
<b>НИЙТ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ</b>										
<b>НИЙТ САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР</b>										
1	Гишүүдийн нийт хадгаламж									
2	Банкнаас авсан зээл	XXXX								
3	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	XXXX								
4	Төслийн зээлийн санхүүжилт	XXXX								
5	Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа	XXXX								
6	Бусад*									
<b>НИЙТ САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР</b>										
Цэвэр зөрүү										
Цэвэр зөрүү /өссөн дүнгээр/										-
<b>Хөрөнгө ба өр төлбөрийн зөрүүг нийт хөрөнгөд харьцуулсан хувь</b>										

\* Тайлбар: - Хугацаагаар ангилж болох бусад хөрөнгө, өр төлбөр

Судалгааны маягтыг бөглөх дарааллын товч заавар:

1/ XXXX нүдийг бөглөхгүй

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх  
захирал

/Нэр/  
/Нэр/

Ерөнхий  
ня-бо

**ХӨРӨНГИЙН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ НЭР**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД						НИЙТ ДҮН	
д/д	Хөрөнгийн ангилал	Зээлийн өрийн үлдэгдэл	Хувь	Эрсдэлийн сангийн хувь	Байгуулбал зохих сан	Байгуулсан сан	Илүү (+), дутуу (-)
<b>A</b>	<b>Нийт зээл</b>		<b>100.00%</b>				
1	Хэвийн зээл			0%			
2	Хугацаа хэтэрсэн			5%			
3	Чанаргүй зээл						
4	а/Хэвийн бус			25%			
5	б/Эргэлзээтэй			50%			
6	в/ Муу			100%			
<b>Б</b>	<b>Нийт ӨБХ</b>		<b>100.00%</b>				
1	Хэвийн ӨБХ			0%			
2	Хугацаа хэтэрсэн ӨБХ			5%			
3	Чанаргүй ӨБХ						
4	а/Хэвийн бус			25%			
5	б/Эргэлзээтэй			50%			
6	в/ Муу			100%			
<b>ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>							
<b>I</b>	<b>ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй)</b>					<b>5.0%</b>	
1	Чанаргүй зээлийн зохистой үзүүлэлт тайлангаар						
2	Харьцааны биелэгдээгүй хувь						

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал

/Нэр/

Ерөнхий ня-бо

/Нэр/

**ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ НЭР**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

/төгрөгөөр/

д/д	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НИЙТ ДҮН
<b>A</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	
1	Касс дахь бэлэн мөнгө	
2	Банкинд байршуулсан харилцах	
3	Банкинд байршуулсан хадгаламж	
4	Богино хугацаат хөрөнгө оруулалт	
5	Зээл (цэврээр)	
6	ӨБХ (цэврээр)	
7	Авлага	
8	Үндсэн хөрөнгө (цэврээр)	
9	Бусад эргэлтийн хөрөнгө	
10	Бусад эргэлтийн бус хөрөнгө	
<b>B</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>	
1	Гишүүдийн нийт хадгаламж	
2	Банкнаас авсан зээл	
3	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	
4	Төслийн зээлийн санхүүжилт	
5	Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа	
6	Хойшлогдсон татварын өр төлбөр	
7	Бусад өр төлбөр	
<b>B</b>	<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>	
1	Гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгө	
2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	
<b>Г</b>	<b>ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ</b>	
1	Нөөцийн сан	
2	Хандив, тусламж	
3	Хадгаламж, хамгаалалтын сан	
4	Нийгмийн хөгжлийн сан	
5	Тогтворжилтын сан	
6	Бусад сан	
7	Хуримтлагдсан орлого/алдагдал	
	<b>ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (60-85 хувь)</b>	<b>60-85%</b>
1	Харьцаа тайлангаар	
2	Харьцааны биелэгдээгүй хувь	
<b>II</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас хэтрэхгүй)</b>	<b>10.00%</b>
1	Харьцаа тайлангаар	
2	Харьцааны биелэгдээгүй хувь	
<b>III</b>	<b>ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (20-80 хувь)</b>	<b>20-80%</b>
1	Харьцаа тайлангаар	
2	Харьцааны биелэгдээгүй хувь	
<b>IV</b>	<b>БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (20 хувиас хэтрэхгүй)</b>	<b>20.00%</b>
1	Харьцаа тайлангаар	
2	Харьцааны биелэгдээгүй хувь	

<b>V</b>	<b>НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГӨ (10 хувиас хэтрэхгүй)</b>	<b>10.00%</b>
1	Харьцаа тайлангаар	
2	Харьцааны биелэгдээгүй хувь	
<b>VI</b>	<b>НӨӨЦИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ (3.0 хувиас доошгүй)</b>	<b>3.00%</b>
1	Харьцаа тайлангаар	
2	Харьцааны биелэгдээгүй хувь	
<b>VII</b>	<b>ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас доошгүй)</b>	<b>5.00%</b>
1	Харьцаа тайлангаар	
2	Харьцааны биелэгдээгүй хувь	
<b>VIII</b>	<b>ХАДГАЛАМЖ ХАМГААЛАЛТЫН САНГИЙН ХЭМЖЭЭ (5 хувиас доошгүй)</b>	<b>5.00%</b>
1	Харьцаа тайлангаар	
2	Харьцааны биелэгдээгүй хувь	
<b>IX</b>	<b>ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН ХЭМЖЭЭ (5 хувиас доошгүй)</b>	<b>5.00%</b>
1	Харьцаа тайлангаар	
2	Харьцааны биелэгдээгүй хувь	

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал

/Нэр/

Ерөнхий ня-бо

/Нэр/

**ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ НЭР**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

/төгрөгөөр/

д/д	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нийт дүн
<b>A</b>	<b>Хүүгийн цэвэр орлого (A1-A2)</b>	
1	Хүүгийн орлого	
2	Хүүгийн зардал	
<b>B</b>	<b>Хүүгийн бус орлого</b>	
<b>B</b>	<b>Хүүгийн бус зардал</b>	
<b>Г</b>	<b>Татварын дараах цэвэр орлого</b>	
<b>Д</b>	<b>Үйл ажиллагааны зардал</b>	
<b>Е</b>	<b>Нийт хөрөнгө</b>	
<b>Ё</b>	<b>Эрсдэлийн сангийн зардал</b>	
<b>Ж</b>	<b>Зээлийн эрсдэлийн сан</b>	
<b>З</b>	<b>Нийт хүүгийн орлого оруулдаг хөрөнгө</b>	
<b>И</b>	<b>Хувь нийлүүлсэн хөрөнгө</b>	
<b>Й</b>	<b>Нийт зээл</b>	
	<b>ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (15 хувиас хэтрэхгүй)</b>	<b>15.0%</b>
1	Харьцаа тайлангаар	
2	Харьцааны биелэгдээгүй хувь	
<b>II</b>	<b>ӨГӨӨЖ</b>	
1	Хөрөнгийн өгөөж	
<b>III</b>	<b>Хүүгийн орлого / Нийт хөрөнгө</b>	
<b>IV</b>	<b>Хүүгийн зардал / Нийт хөрөнгө</b>	
<b>V</b>	<b>Хүүгийн цэвэр орлого / Нийт хөрөнгө</b>	
<b>VI</b>	<b>Хүүгийн бус орлого / Нийт хөрөнгө</b>	
<b>VII</b>	<b>Хүүгийн бус зардал / Нийт хөрөнгө</b>	
<b>VIII</b>	<b>Эрсдэлийн сангийн зардал / Нийт хөрөнгө</b>	
<b>IX</b>	<b>Хүүгийн орлого / Хүүгийн орлого оруулдаг хөрөнгө</b>	
<b>X</b>	<b>Зээлийн эрсдэлийн сан / Нийт зээлийн өрийн үлдэгдэл</b>	

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал /Нэр/

Ерөнхий ня-бо /Нэр/

**ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ НЭР**  
**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

/төгрөгөөр/

д/д	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нийт дүн
<b>А</b>	<b>ТҮРГЭН БОРЛОГДОХ ХӨРӨНГӨ</b>	
1	Касс дахь бэлэн мөнгө	
2	Банкинд байршуулсан харилцах	
3	Банкинд байршуулсан хадгаламж	
4	Зээл (30 хоногт төлөгдөх зээл)	
<b>Б</b>	<b>БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨР</b>	
1	Гишүүдийн хугацаагүй мөнгөн хадгаламж	
2	Гишүүдийн хугацаатай мөнгөн хадгаламж (30 хоногоос доош)	
3	Гишүүдийн хугацаатай мөнгөн хадгаламж (30 хоногоос дээш)	
4	30 хоногт төлөх зээл	
5	Бусад богино хугацаат өр төлбөр	
6	Урт хугацаат өр төлбөр	
	<b>ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	
<b>В</b>	<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (4 хувиас дээш)</b>	<b>4.0%</b>
1	Зохистой харьцаа тайлангаар (А-Б1-Б2-Б4-Б5)/(Б3+Б6)	
2	Харьцааны биелэгдээгүй хувь (В1-В)	

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал

/Нэр/

Ерөнхий ня-бо

/Нэр/

**ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ДАГАЖ МӨРДӨХ ҮЗҮҮЛЭЛТ  
ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ НЭР  
ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР
<b>А ХӨРӨНГИЙН ЧАНАР БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
1	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+ илүү, -дутуу)		
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас хэтрэхгүй	
3	НЭГ ГИШҮҮНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	
4	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	
<b>Б ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
1	НИЙТ ХӨРӨНГӨ /АКТИВ/-Д ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	60%-85%	
2	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	
3	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-80%	
4	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	
5	НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	
6	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас доошгүй	
7	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ		
8	ХАДГАЛАМЖ ХАМГААЛАЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ		
9	ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ		
<b>В ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ</b>			
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас хэтрэхгүй	
<b>Г ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР</b>			
11	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	4%-аас доошгүй	
<b>Д ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)</b>			
12	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ		

Нийт ..... зохистой харьцааны шалгуур үзүүлэлт(ЗХШҮ)-ээс

хангаж ажилласан байна.

**ТАМГА**

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал  
Ерөнхий ня-бо

/Нэр/  
/Нэр/